**УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН ХЭМЖЭЭНД “АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХҮРЭЭНД 2022 ОНЫ ХАГАС ЖИЛД ХЭРЭГЖҮҮЛСЭН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2022.06.03

| Д/д | Зорилго | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Хариуцах ажилтан | Хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр ₮ | Хэрэгжүүлсэн ажлууд |
|---|---|---|---|---|---|---|
| **Нэг. Шударга, хариуцлагатай, хууль дээдэлсэн албыг бэхжүүлэх, ёс зүйг дээшлүүлэх** | | | | | | |
| 1 | Хууль, дүрэм журмын хэрэгжилтийг ханган ажиллах | Авлигын эсрэг хууль тогтоомжуудыг ажилтан болон иргэдэд сурталчлах, таниулах | I улирал | ЭБАТ | - | I. Авлигын эсрэг хууль, Нийтийн албан нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудыг эмнэлгийн Гадаад цахим хуудсанд байршуулан иргэд болон ажилтнууд уншиж танилцах боломжоор хангасан.<br><br>II. УНТЭ-ийн нийт удирдах албан тушаалтнуудад Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудыг мөрдүүлэх, хэрэгжилтийг хангах зорилгоор дээрх хуулиудыг хууль, эрх зүйн хавтсанд байршуулж, ажилтнууд танилцах бүрэн боломж, нөхцлөөр хангах, нэгжийн хамт олны цахим сүлжээнд байршуулах, сургалт болон хэлэлцүүлэг зохион байгуулах байдлаар хууль эрх зүйн мэдлэг олгох, бататгах үйл ажиллагааг дотооддоо зохион байгуулах болон хуулийн холбогдох заалтуудыг онцгойлон анхаарч ажиллах талаар “Хуулийг мөрдөн ажиллах тухай” албан бичгийг 2021.03.12 1/242, 2021.12.16 1/1263 тоот албан бичгүүдээр хүргүүлэн ажиллаж байна.<br>Уг албан бичгүүдэд дараах зүйлсийг онцгойлон анхаарч ажиллахыг дурдсан. Үүнд:<br>1. Удирдах албан тушаалтнууд захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох, хандив авах болон ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй бусад |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тохиолдолд Эмнэлгийн Ерөнхий захиралд албан ёсоор мэдэгдэн тухай бүрт Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийг мөрдөн ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдлын талаар мэдэгдэн шийдвэрлүүлж ажиллах;<br>2. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой эм, эмнэлгийн хэрэгсэл, бараа ажил, үйлчилгээ худалдан авах, ажил, үйлчилгээ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог томилох тушаалыг тухай бүрт хариуцсан мэргэжилтнүүдэд танилцуулан хуулийн хүрээнд холбогдох ажлыг зохион байгуулан шилэн дансанд тогтмол байршуулан ажиллах;<br>3. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн нийт удирдах ажилтан, алба, төв, тасгийн эрхлэгч, дарга нар, ажилтнууд үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн гуравдугаар бүлэг “Албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт”-ын зүйл, заалтуудыг мөрдөн ажиллах;<br>4. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн нийт удирдах ажилтан, алба, төв, тасгийн эрхлэгч, дарга нар Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу Хувийн ашиг сонирхлын |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | болон хөрөнгө орлогын мэдүүлгийг мэдүүлэх, удирдах албан тушаалтан мэдүүлгээ мэдүүлсний дараа хөрөнгө, орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн бол түүнийг тухай бүр 30 хоногийн дотор мэдүүлэх;<br>5. Удирдах албан тушаалтан болон алба, төв, тасгийн эрхлэгч дарга нар нэгжийн ажилтнууддаа эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх болон ажлаа гүйцэтгэсний төлөө аливаа бэлэг, төлбөр авахыг хориглох, зөвшөөрөгдсөн төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийг эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан шууд гардан хүлээн авахыг хориглох бөгөөд байгууллагын ахлах касс, цахим бүртгэлийн касс, Эмнэлзүйн албаны ЭМД-ын нэгжийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөр хариуцсан ажилтан, Эрүүл мэндийг дэмжих төвийн тусламж, үйлчилгээний бүртгэл, төлбөр хариуцсан ажилтнуудад тушаалгах, уг зохицуулалттай холбоотой хүндрэлтэй асуудлууд үүсвэл Захиргаанд тухай бүр мэдэгдэн шийдвэрлүүлж ажиллах;<br>6. Улсын нэгдүгээр төв эмнэлгээс бусад хувийн хэвшлийн аж ахуй нэгж, байгууллагатай хийх аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгасан байх;<br>7. Нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг боловсруулахдаа ажилтнуудын санал, шүүмжлэлийг хүлээн авах боломжийг бүрдүүлэх; |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 8. Эмнэлийн мэргэжилтэн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцдаа үйлчлүүлэгчдэд бусад хувийн эмнэлэг, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сангийн талаар онцолж санал болгох, сурталчлах, эм, эмнэлгийн хэрэгсэл, бусад зүйлс худалдан боруулахыг хориглох;<br>9. Алба, төв тасаг нэгжүүд уг албан бичгийн нэгдүгээр хавсралтаар батлагдсан хүснэгтийн дагуу давхар ажил эрхлэлтийн байдлыг шинэчлэн судалж, ажилтнуудаар гарын үсэг зуруулан баталгаажуулах;<br>10. КОВИД-19 цар тахлын улмаас нийтийг хамарсан өргөн хүрээний сургалтыг танхимаар зохион байгуулах боломжгүй байгаатай холбоотой хууль эрх зүйн болон ёс зүйн цахимаар зохион байгуулагдаж буй сургалтуудад ажилтнуудаа бүрэн хамруулах зохион байгуулалт, зохицуулалтуудыг хийж ажиллах;<br>11. Авлигатай тэмцэх газраас гаргасан тараах материал, зурагт хуудсыг тухай бүрт нэгжийн дотор байршуулан ажилтан, үйлчлүүлэгчдэд сурталчлах;<br><br>III. УНТЭ-ийн Удирдах албан тушаалтнууд буюу ХАСХОМ мэдүүлдэг албан тушаалтнуудад 2022.01.11-ний өдөр ХАСХОМ мэдүүлэхтэй холбоотой Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох заалтуудыг танилцуулан сургалтыг зохион байгуулсан. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br><br><br><br>**Хавсралт – 1** “Хуулийг мөрдөн ажиллах тухай” албан бичгийг 2021.03.12 1/242, 2021.12.16 1/1263 тоот албан бичгүүдийг хавсаргав. |
| | | Хууль, тогтоомжид заасны дагуу албан тушаалд томилогдох албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-т хянуулж, томилох | Тухай бүр | Томилох эрх бүхий албан тушаалтнууд ЭБАТ | | УНТЭ-т шинээр томилогдох болон албан тушаал дэвших албан тушаалтнуудын Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-т тогтсол хянуулан, цахим бүрдүүлэлтийн системд бүртгэн ажиллаж байна.<br> |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар дараах албан тушаалтнуудын ХАСУМ-ийг АТГ-т хянуулаад байна.<br>1. УНТЭ-ийн Ерөнхий захирлын 2022.02.11 1/205 тоот албан бичгээр Т.Одхүүг Эдийн засаг, маркетингийн албаны даргаар томилохоор нэрийг дэвшүүлж, АТГ-ын 2022.02.18 05/2265 тоот албан бичгийг үндэслэн 2022.03.01-ний өдрийн Ерөнхий захирлын б/94 тоот тушаалаар Эдийн засаг, маркетингийн албаны даргаар томилов.<br>2. УНТЭ-ийн Ерөнхий захирлын 2022.04.12 1/498 тоот албан бичгээр М.Бөхчулууг Амбулаторийн эрхлэгчээр томилохоор нэрийг дэвшүүлж, АТГ-ын 2022.04.25 05/5661 тоот албан бичгийг үндэслэн 2022.04.29-ний өдрийн Ерөнхий захирлын б/182 тоот тушаалаар Амбулаторийн эрхлэгчээр томилов.<br>3. УНТЭ-ийн Эмнэлгийн Ерөнхий захирлын 2022.04.19 1/532 тоот албан бичгээр Б.Тэлмэнг Эмнэлгийн хэрэгсэл, аж ахуй, үйлчилгээ, хангамж түгээлтийн албаны даргаар томилохоор нэрийг дэвшүүлж, АТГ-ын 2022.04.21 05/5503 тоот албан бичгийг үндэслэн 2022.05.02-ны өдрийн Ерөнхий захирлын б/194 тоот тушаалаар Эмнэлгийн хэрэгсэл, аж ахуй, үйлчилгээ, хангамж түгээлтийн албаны даргаар томилов.<br>4. УНТЭ-ийн Ерөнхий захирлын 2022.04.28 01/572 тоот албан бичгээр Б.Одончимэгийг Санхүү бүртгэлийн албаны даргаар томилохоор нэрийг дэвшүүлж, АТГ-ын 2022.04.29 05/5892 тоот албан бичгийг үндэслэн 2022.05.05-ний өдрийн Ерөнхий захирлын |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | б/202 тоот тушаалаар Санхүү бүртгэлийн албаны даргаар томилов.<br><br> |
| | | УНТЭ-ийн удирдах, ХАСХОМ мэдүүлэх шаардлагатай албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүлээн авч АТГ, ЭМЯ-нд тайланг хуулийн хугацаанд хүргүүлэх | Тухай бүр | ЭБАТ | - | УНТЭ-ийн ХАСХОМ мэдүүлэх 45-н албан тушаалтны нэрсийг 2022.01.03-ны өдрийн 1/03 тоот албан бичгээр ЭМЯ-нд хүргүүлсэн.<br><br>Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг<br>14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, С.Зоригийн гудамж-2, Утас/факс: (976-11) 32-38-57<br>E-mail: firsthospital@fchm.edu.mn<br>2022.01.03 № 1/03<br>танай ________-ны № ________-т<br>ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ХУУЛИЙН ХЭЛТЭСТ<br>Нэрс хүргүүлэх тухай<br>2021 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн албан тушаалтнуудын нэрсийг хавсралтаар гарган хүргэж байна.<br>Хавсралт 21 хуудастай.<br>ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ХИШИГЖАРГАЛ<br>Удирдах, ХАСХОМ мэдүүлэх шаардлагатай 45-н албан тушаалтны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд буюу 2022.02.15-ны өдрийн дотор багтаан мэдүүлж, тайланг 2022.02.22-ны өдрийн 1/255 тоот албан бичгээр ЭМЯ-ны Захиргааны, удирдлагын газрын Хуулийн хэлтэст хүргүүлсэн. |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>
<br>АТГ-ын “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд жил бүр Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган хагас, бүтэн жилээр ЭМЯ-нд тайланг хүргэн ажиллаж байна.
<br>2021 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны тайланг ЭМЯ-нд 2021.12.13-ны өдрийн 1/1249 албан тоот бичгээр хүргүүлэв.
<br>
<br>Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг
<br>Анхдагч, Манлайлагч
<br>14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, С.Зоригийн гудамж-2, Утас/факс: (976-11) 32-38-57
<br>E-mail: firsthospital@fchm.edu.mn
<br>2021.12.13 № 1/1249
<br>танай ____________-ны № ____________-т
<br>ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ХУУЛИЙН ХЭЛТЭСТ
<br>Тайлан хүргүүлэх тухай
<br>Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн ХЭГ/141 тоот “Танилцуулга хүргүүлэх тухай”, 2021 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн ХЭГ/432 тоот “Албан бичиг хүргүүлэх тухай”, Авлигатай тэмцэх газрын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 01/14527 тоот "Мэдээлэл хүргүүлэх тухай", 2021 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01/696 тоот “Авлигын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай”, 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01/428 тоот "Зөвлөмжийн хэрэгжилтийг хангахад анхаарч ажиллах тухай", Эрүүл мэндийн яамны 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 2/460 тоот “Авлигын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай”, 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 2/458 тоот “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн тухай”, 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 1а/1060 тоот “Албан бичиг хүргүүлэх тухай” албан бичгүүд болон Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллав.
<br>Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний 2021 оны жилийн хэрэгжилтийн тайланг хавсралтаар хүргэж байна.
<br>Хавсралт 51 хуудастай.
<br>ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ХИШИГЖАРГАЛ
<br>АТТ026
<br>**<u>Хавсралт – 2 нэрсийн жагсаалтыг хавсаргав</u>**</td></tr>
<tr><td></td><td></td><td>Давхар ажил эрхэлдэг албан тушаалтан, ажилтнуудтай хариуцлагын гэрээ байгуулах</td><td>Жилдээ</td><td>ЭБАТ</td><td>-</td><td>УНТЭ-ийн нийт ажилтнуудаас авсан давхар ажил эрхлэлтийн судалгаагаар 36 албан тушаалтан, ажилтан давхар ажил эрхэлдэг талаар мэдүүлсэн. Эмнэлгийн хуулийн зөвлөх, ЭБАТ хамтран давхар ажил эрхэлж буй ажилтнуудад</td></tr>
</table>

холбогдох хууль эрх зүйг танилцуулан албан ёсоор давхар ажил эрхлэх хүсэлтийг хүлээн авч Эмнэлгийн Ерөнхий захиралд танилцуулан шийдвэрлүүлсэн. Давхар ажил эрхэлдэг албан тушаалтан, ажилтнуудтай хариуцлагын гэрээ байгуулахаар гэрээний төслийг боловсруулаад байна.

| № | Нэр | Албан тушаал | Давхар ажил эрхлэлтийн байдал | Давхар ажил эрхлэлтийн хугацаа |
|---|---|---|---|---|
| 1 | Б.Хишигжаргал | Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч | АШУҮИС | Гэрээт багш |
| 2 | Д.Баямагнай | МТА-ны инженер | Сөүл сонгодо эмнэлэгт зөвлөх инженер | Ажлын бус цаг |
| 3 | Б.Батсайхан | ЭШСТ-ийн их эмч | ММЗЭНХолбоо Нарийн бичгийн дарга | Ажлын бус цаг |
| 4 | Л.Од-Эрдэнэ | ЭШСТ-ийн их эмч | Нарт-Эрдэнэс бөөрний эмнэлэг Зөвлөх эмч | Бямба гаригт 4 цаг |
| 5 | Ж.Нансалмаа | СЗЭТ-ийн ахлах сувилагч | Дархан - Оточ эмнэлэг сувилагч | Бямба гаригт |
| 6 | Д.Баян-Өндөр | УАТ-ийн дарга | Гранд эмнэлэг, 3-р эмнэлэг зөвлөх багш | Утсаар зөвлөгөө |
| 7 | М.Отгонбаяр | ХҮСҮСТ-ийн дарга | Сонгодо эмнэлэгт зөвлөх эмч, багш | Ажлын бус цагт |
| 8 | О.Чойдог | ХҮСҮСТ-ийн их эмч | Сонгодо эмнэлэг их эмч | Ажлын бус цаг 7 хоногт 2 цаг |
| 9 | Н.Энхтайван | ХҮСҮСТ-ийн их эмч | Сонгодо эмнэлэг их эмч | Ажлын бус цаг 7 хоногт 1 цаг |
| 10 | Д.Эрдэнэзул | МХНТ-ийн сувилагч | Гарьдманлай эмнэлэг сувилагч | Ажлын бус цаг Ням гариг 24 цаг |
| 11 | В.Дэлгэрмаа | ДОТ-ийн их эмч | Хүмүүн эмнэлэг эхоны эмч | Даваа, пүрэв гаригт 17.30-аас 1 цаг |
| 12 | Ш.Бүжинлхам | ДОТ-ийн их эмч | Налайх ЭМТөв зөвлөх эмч | Ажлын бус цаг Бямба ням гаригт |
| 13 | А.Хажидмаа | ДОТ-ийн их эмч | БГД-ийн 1-р хорооны өрхийн эмнэлэг эхо эмч | Бямба гариг 09-12 цагийн хооронд |
| 14 | Л.Энхсайхан | МЭТ-ийн дарга | АШУҮИС-ийн цагийн багш, ОМИС цагийн багш, 401 анги НЭ зөвлөх эмч | Ажлын бус цаг 1 цаг |
| 15 | Б.Энхзориг | МЭТ-ийн их эмч | Мандал даатгалын газар зөвлөх | Ажлын бус цаг 1 жил |
| 16 | Т.Рэгзэдмаа | УХСТ-ийн их эмч | Алирго смелл ХХК эмч | Ажлын бус цаг 17-18 цагт |
| 17 | Ж.Хонгорзул | СБА-ны нягтлан бодогч | УНТЭ-ийн ҮЭХ ня-бо | Ажлын бус цаг 1 жил |
| 18 | Э.Алтандөш | ЧХХСМЗТ-ийн их эмч | ЭМЖЖ, Ачтан, БГДНЭ зөвлөх | Ажлын бус цаг |
| 19 | Л.Бямбасүрэн | ЧХХСМЗТ-ийн эрхлэгч | Сонгодо эмнэлэгтзөвлөх эмч | Ажлын бус цаг |
| 20 | О.Ганбат | ЕМЗТ-ийн тасгийн эрхлэгч | Амарлих газар, ТТАХН эмнэлэг, Номун эмнэлэг, Натул эмнэлэг мэс заслын зөвлөх эмч | Шаардлагатай үед утсаар зөвлөгөө өгнө |
| 21 | Л.Амгалан | ЕМЗТ-ийн тасгийн их эмч | Гранд мед эмнэлэг, ШШГЕГ 401 анги зөвлөх эмч | Шаардлагатай үед Бямба гаригт |
| 22 | Ц.Ишдорж | ЕМЗТ-ийн их эмч | СӨҮЛ эмнэлэг мэс заслын зөвлөх эмч | Шаардлагатай үед Бямба гаригт |
| 23 | Б.Ганзориг | ЕМЗТ-ийн их эмч | ЗХЭМҮТ мэс заслын зөвлөх эмч | Шаардлагатай үед дуудлагаар |
| 24 | Л.Цацалмаа | ЕМЗТ-ийн сувилагч | Гарьдманлай эмнэлэг сувилагч | Ажлын бус цаг Ням гаригт 24 цаг |
| 25 | З.Жүгдэр | ГЭТ-ийн ахлах сувилагч | АШУҮИС-д гэрээт багш | |
| 26 | Г.Ганцэцэг | СЗЭТ-ийн хөдөлгөөн засалч | АШУҮИС-д гэрээт багш | |
| 27 | Ц.Амаржаргал | СА-ны дарга | АШУҮИС-д гэрээт багш | |
| 28 | Ц.Дэнсмаа | УНСЭТ-ийн их эмч | Эв бариа засал эмнэлэгт их эмч | Ажлын бус цагаар ажиллах |
| 29 | Д.Энхзул | НСМЗТ-ийн их эмч | Хувийн эмнэлэгт их эмч | Ажлын бус цагаар хувийн эмнэлэгт |
| 30 | С.Энхтуул | НСМЗТ-ийн эрхлэгч | ТЭУ хувийн эмнэлэгт их эмч , Ю мед эмнэлэгт их эмч | Ажлын бус цагаар |
| 31 | Б.Түвшинтөгс | НСМЗТ-ийн их эмч | ТЭУ хувийн эмнэлэгт их эмч | Ажлын бус цагаар |
| 32 | Б.Төмөрбаатар | НСМЗТ-ийн их эмч | ШШГЕГ харьяа 401 дугаар ангийн нэгдсэн эмнэлэгт их эмч, ТЭУ хувийн эмнэлэг их эмч | Ажлын бус цагаар |
| 33 | Т.Ундармаа | НСМЗТ-ийн их эмч | ТЭУ хувийн эмнэлэгт их эмч | Ажлын бус цагаар |
| 34 | З.Мэндсайхан | ЧХХСМЗТ-ийн их эмч | Асралт мед, ТЭУ эмнэлэг, БГДЭМН, СХДЭМН-д дуудагдаж ажилладаг | Ажлын бус цагаар |
| 35 | Э.Баясгалан | ЭМДТ-ийн дарга | Юби Онкомед хувийн эмнэлэг | Ажлын бус цагаар |
| 36 | С.Янжмаа | ДШСДТ-ийн дарга | Этүгэн их сургуульд багш | Ажлын бус цаг |

**Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй, ил тод байдлыг ханган ажиллах**

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2 | Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг хангах | Цахим хуудасны үйл ажиллагааг боловсронгуй болгож, иргэдийн мэдээлэл авах боломж нөхцлийг бүрдүүлэх | Жилдээ | Мэдээлэл технологийн алба<br><br>ЗАА-ны Олон нийттэй харилцах, хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн<br><br>Эдийн засаг, маркетингийн алба<br><br>ЗХНА<br><br>ЭТҮЧАБА<br><br>СБА | - | 2021 оны 05 сарын 10-ний өдрийн ерөнхий захирлын А/112 тоот тушаалаар “УНТЭ-ийн гадаад хуудсанд шинэчлэл хийх, цахим хуудсны англи хэл дээрх хувилбарыг шинээр хийх, мэдээллийн ил тод байдлыг сайжруулахтай холбоотой зохион байгуулан ажиллах” ажлын хэсгийг байгуулсан. Уг ажлын хэсэг 3 удаа хуралдан unte.moh.gov вэб хуудсанд шинээр оруулах 7 бүлэг саналыг нэгтгэн вэб хуудас хийсэн Вэбтон ХХК-руу хүргүүлсэн бөгөөд 2021 оны 7 сард шинээр батлагдсан брэндбүүкийн загвараар дээрх засвар өөрлөлтүүд хийгдсэн.<br>Байгууллагын ил тод байдлыг эрчимжүүлэн сайжруулах чиглэлээр дээрх тушаалыг шинэчлэн 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/163 тоот тушаалаар “Мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах ажлын хэсэг” байгуулагдсан. Тус ажлын хэсэг 2022 оны 05 дугаар сарын 24-ны өдөр 17 чиглэл бүхий ажлыг хугацаатай хийж гүйцэтгэхээр төлөвлөгөөг Ерөнхий захирлаар батлуулан ажиллаж байна. “Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам”, “Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системийн үйл ажиллагааны журам” 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдөр Засгийн газрын хуралдаанаар батлагдсан боловч нийтэд ил болоогүй байгаа тул байгууллагын дотоодод мөрдөх журмыг төсөл хэлэлцэх шатандаа байна.<br>Мөн ил тод байдлыг сайжруулах зорилгоор мэдээллийн баяжилтыг хариуцсан ажилтан хийж ажиллаж байна.<br><br>**ХАСХОМ хариуцсан эрх бүхий албан тушаалтнаас өгсөн санал:**<br>1. Ил тод байдал<br>a. Үйл ажиллагааны ил тод байдал<br>b. Хүний нөөцийн ил тод байдал<br>i. сул орон тооны зар<br>ii. албан хаагчийн ёс зүйн дүрэм<br>c. Төсөв санхүүгийн ил тод байдал<br>d. Худалдан авах ажиллагааны ил тод байдал<br>2. Авилгын эсрэг үйл ажиллагаа<br>a. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө<br>b. Тайлан<br>c. Холбогдох мэдээ, мэдээллийг байршуулах |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>**<u>Unte.moh.gov.mn: Засварлах санал</u>**<br>Нүүр хэсэгт:<br>1. Тогтмол хэсэгт: Цагийн хуваарь, нээлттэй ажлын байр, холбоо барих гэсэн хэсэгт<br>1. Амбулаторийн үзлэгийн цаг захиалах хэсгийг оруулах<br>2. Холбоо барих хэсгийн доод талд түгээмэл асуулт, хариулт гэж оруулах<br>2. Эмнэлгийн лого зураг болон үнэт зүйл байгаа хэсэгт<br>1. Өдөр тутмын үндсэн үзүүлэлтийн мэдээллийг оруулах<br>2,715 11,680 2,427 66,838<br>2. Үнэт зүйл хэсэгт танилцуулга видео харагддаг байх<br>3. Үндсэн menu хэсэгт Нийгмийн эрүүл мэнд гэсэн цэс оруулах<br>4. Ил тод байдал хэсэгт Авилгын эсрэг үйл ажиллагаа цэс оруулах<br>5. Сэтгэл ханамжийн судалгаа авах хэсгийг шинээр орууулах<br>6. Мэдээ, мэдээлэл хэсэгт оруулсан мэдээллийг энгийн мэдээллийн цахим хуудастай адил болгох, харагдах байдал болоод оруулсан мэдээллийг дэлгэрэнгүй дарж үздэг болгох гэх мэт<br>7. Тусламж үйлчилгээ цэсний дэд menu хэсэгт оруулсан мэдээнүүдийн доод хэсэгт тогтмол ведио бичлэг харагддаг байх<br>***<u>УНТЭ-ийн мэдээллийн ил тод байдлын талаар хэрэгжүүлсэн ажлууд</u>***<br>Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь иргэд болон ажилтнуудад мэдээллийг дараах эх сурвалжуудаар хүргэж байна. Үүнд:<br>1. Улсын нэгдүгээр төв эмнэлэг гадаад сайт http://unte.moh.gov.mn/<br>2. Улсын нэгдүгээр төв эмнэлэг 57522 дагагчтай пэйж хуудас<br>3. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хамт олон facebook хаалттай /903 ажилтантай/<br>4. Мэдээллийн самбарууд /УНТЭ-ийн захиргаанд 3, тусламж, үйлчилгээ үзүүлж буй нэгж тус бүрт дотоод мэдээллийн самбар, буланг ажиллуулж байна/<br>5. Амбулаторийн хэсэг болон ЭМД-ын хэсэг, амбулаторийн үений мэс заслын хэсэгт байрлуулсан электрон дэлгэцүүдээр тухай бүр шаардлагатай мэдээллүүдийг урсгаж байна.<br>6. arslan.mn сайт – тай хамтран ажиллах гэрээний хүрээнд мэдээ мэдээллийг байршуулан ажиллаж байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 7. Шаардлагатай тохиолдолд зарим телевизтэй хамтран ажиллаж байна.<br><br><br>УНТЭ-ийн гадаад сайт<br><br><br>Facbook<br><br><br>Page хуудас |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>Мэдээллийн самбар<br><br>УНТЭ-ийн фейсбүүк, пейж хуудас дээр тавигдаж буй мэдээллүүдийг үзсэн иргэдийн хандалт болон насны бүтцээр хувьд авч үзвэл:<br><br>2022 он гарсанаас хойш хандалтын тоо өсөх хандлагатай байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>Жишээ нь нийтэлсэн нэг мэдээлэл олон нийтэд хэрхэн хүрч буй сэтгэл ханамжийн байдал<br><br> |




2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар Улсын нэгдүгээр төв эмнэлэг 57522 дагагчтай пэйж хуудсанд нийт 77 нийтлэл, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хамт олон facebook хаалттай /903 ажилтантай/ группэд нийт 150 нийтлэл тавигдсан байна.

***УНТЭ-ийн тусламж, үйлчилгээний ил тод байдлын талаар хэрэгжүүлсэн ажлууд***

*Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ*

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын 202.06.11-ний өдрийн А/233 тоот “УНТЭ-ийн хэвтэлт, гаргалтын нэгдсэн тогтолцоог нэвтрүүлэх тухай” тушаалыг батлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

УНТЭ нь амь тэнссэн байдалтай Яаралтай түргэн тусламжийн тасгаар ирж буй үйлчлүүлэгчийг шууд хүлээн авч эрэмбэлэн хэвтүүлэх болон шаардлагатай тусламж, үйлчилгээг хүргэн ажилладаг.

Иргэн амбулаториор үйлчлүүлж буй тохиолдолд е – health програмаар дамжуулан хэвтэх захиалгыг хийдэг. Энэхүү захиалга нь дараах 3-н төлөвт бүртгэгддэг.

1. Яаралтай
2. Хойшлуулашгүй
3. Төлөвлөгөөт

УНТЭ-ийн Эмнэлзүйн албанаас Е – health програмад бүртгэгдсэн цахим захиалгын дагуу

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчлүүлэгчийг хэвтэх өдрийн өмнөх өдөр утсаар дуудан хэвтүүлэх зохицуулалтыг хийн ажиллаж байна. Хэвтүүлэн эмчлэхтэй холбоотой хүлээгдэл чирэгдлийг бууруулах ажлын хүрээнд эмнэлгийн өргөтгөл хэсгийг дотрын нэгдсэн тасгийн зохион байгуулалтаар зохицуулалтыг хийн ажиллаж байна.<br>*Амбулаторийн тусламж, үйлчилгээ*<br>Амбулаторийн тусламж, үйлчилгээ нь УНТЭ-ийн ерөнхий захирлын 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/320 тоот “Амбулаторын үйл ажиллагааны түр журам"-аар, амбулаторийн хүлээгдлийг ЭМС-ын 2012 оны 375 болон 427 тоот, УНТЭ-ийн Даргын 2013 оны 12-р сарын 05-ны өдрийн 55 тоот тушаалыг үндэслэн тусламж үйлчилгээний хүлээгдлийг бүртгэх, мэдээлэх, яаралтай тусламжийн “**FOLLOW UP**” хүлээгдлийн удирдлагыг хэрэгжүүлэх “Гэрлэн дохио”-ны удирдамжийн дагуу Realtime програмд өдөр бүр мэдээлэгдэж, цахим бүртгэлийн дэлгэцээр амбулаторийн үзлэгийн хүлээгдлийн мэдээ хүрч байна.<br>Амбулаторийн кабинетийн үзлэг 1-3 хоногт хийгдэж байвал ногоон, 3-6 хоногт шар, 7-оос дээш хоногт улаан гэрлээр анхааруулан тухай бүр зохицуулалтыг хийн ажиллаж байна.<br><br>Амбулаторийн үзлэгийн хүлээгдлийг бууруулах чиглэлээр дараах зохицуулалтыг хийн ажиллаж байна. Үүнд:<br>1. Цаг цуцлалт – амбулаторийн кабинетийн үзлэгийн цаг авсан үйлчлүүлэгч цагтаа ирээгүй 1 цаг хоцорсон тохиолдолд тухайн үзлэгийн цагийг цуцлан дараагийн үйлчлүүлэгчийг үзэх зохицуулалтыг хийдэг. Амбулатор өдөрт дунджаар цагтаа |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ирээгүй 135-305 үйлчлүүлэгчийн цагийг цуцлан ажиллаж байна.<br>2. Нэмэлт цонхоор бүртгэх – Амбулаторийн кабинетийн ачаалал их үед хүлээгдлийг бууруулах зорилгоор хүлээгдэл их тухайн кабинетэд нэмэлт цонх нээж, өдөрт дунжаар 5-10 үйлчлүүлэгчийг бүртгэж байна. Хүлээгдэл их дотрын кабинетуудад нэмэлт цонх нээн өдөрт дунджаар 35-70 хүнийг нэмэлтээр бүртгэн үзэж байна.<br>3. Дүрс оношилгоо, дуран зэрэг оношилгоо шинжилгээний кабинетуудын цагийг 7 хоног тутамд үйлчлүүлэгчид олгож байна. Ингэснээр зохиомол хүлээгдлийг бууруулж, нягтаршил сайжирч байна.<br>4. Эхо оношилгоонууд, рентген зураг, холтер, зүрхний ачаалалтай бичлэг зэрэг кабинетуудын цагийг товлолт үйлчилгээгээр оператор урьдчилан утсаар ярьж, үзүүлэх боломжгүй үйлчлүүлэгчийн цагийг цуцлан дараагийн үйлчлүүлэгч үзүүлэх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.<br>5. ЭМЯ-наас нэгдсэн цаг захиалгын төвийн 1800-0119 дугаараар иргэдэд үзлэгийн цагийг олгож байна. Тус төвд УНТЭ-ийн цахим бүртгэлийн ажилтан Д.Надмидцэрэн, Д.Цэндбазар нар ажиллаж байна.<br>6. УНТЭ-ийн үзлэгийн цаг захиалгын 1900-2111 дугаараар 21 аймгийн болон хотын харьяалалтай дүүргийн иргэдийн үзлэгийн цагийг бүртгэж байна. Ингэснээр иргэд, үйлчлүүлэгчийн цагийг хэмнэх, ажлаа төлөвлөх боломжийг бүрдүүлээд зогсохгүй эмнэлгийн ачаалал, хүлээгдлийг бууруулах, халдвараас сэргийлэх зэрэг давуу талтай. . |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 7. Иргэдэд хүлээгдэл чирэгдэлгүй цахимаар буюу e-mongolia –аар цаг авах боломж бүрдсмэн.<br><br>Ажилтнуудыг албан бус төлбөртэй холбоотой эрсдэлд орохоос сэргийлж дараах ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:<br>1. ЭМДҮЗ-ийн 2022.01.28-ны өдрийн 01 тоот “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга журам шинэчлэн батлах тухай” тогтоолыг нийт ажилтнуудад Эмнэлзүйн алба болон Мэдээлэл технологийн албанаас тус тус сургалт хийн танилцуулсан.<br>2. Амбулаторийн цахим бүртгэлийн цахим бүртгэгч нар, ахлах касс, амбулаторийн касс, ЭМД-ын хэсэгт төлбөртэй тусламж үйлчилгээний ЭМДҮЗ-ийн 2022.01.28-ны өдрийн 01 тоот “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга журам шинэчлэн батлах тухай” тогтоолыг байршуулан ажиллаж байна.<br><br>ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ<br>2022 оны 01 сарын 28 өдөр Дугаар 01 Улаанбаатар хот<br>Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай<br>Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 14 дүгээр зүйлийн 14.9.8 дахь заалт, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2, 19 дүгээр зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.1, 21 дүгээр зүйлийн 21.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:<br>1.“Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ”-г нэгдүгээр, “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх төлбөрийн арга”-ыг хоёрдугаар, “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээний нэгж тохиолдлыг тооцох, тохиолдлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх журам”-ыг гуравдугаар, “Төлбөрийг нь төр хариуцан амбулаториор эмчлэх өвчин, эмгэг ба түүнд хэрэглэх эмийн жагсаалт”-ыг дөрөвдүгээр, “Төлбөрийг нь төр хариуцах эмийн санхүүжилтийг тооцох, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх журам”-ыг тавдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.<br>2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд даалгасугай:<br>2.1. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Ц.Эрдэмбилэг/-д:<br>2.1.1. энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхэд эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар шуурхай хангах арга хэмжээг авч ажиллах;<br>2.1.2. эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчид үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдлыг хянахад ашиглаж байгаа удирдлага, мэдээллийн систем, програмд холбогдох өөрчлөлт хийх;<br>2.1.3. Энэхүү тогтоолын хэрэгжилттэй уялдуулан Эрүүл мэндийн сайдаас батлах холбогдох дүрэм, журам, тусламж, үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах;<br>2.2. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар /Л.Бямбасүрэн/-д:<br>2.2.1. эрүүл мэндийн даатгалын цахим (HIGS) систем болон програм хангамжид шаардлагатай нэмэлт, өөрчлөлт хийх;<br>2.2.2. эрүүл мэндийн байгууллага, даатгуулагчаас холбогдох журамд заасныг зөрчиж нэмэлт төлбөр авсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар эрүүл мэндийн даатгалын байгууллага, эрүүл мэндийн байгууллага хооронд байгуулах гэрээнд тодорхой тусгах; |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3. “ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ ТА ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭНГ АЛБАН БУС ТӨЛБӨРИЙН АСУУДАЛД ӨРТӨХӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЖ, ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙГ ЗӨВХӨН ЗӨВШӨӨРӨГДСӨН КАССАНД ТУШААНА УУ!” гэсэн санамж бичгийг амбулаторийн үйлчлүүлэгчийн төвлөрсөн хэсгүүдэд байршуулан ажиллаж байна.<br> |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | |    |
| | | АТГ-аас гаргасан ТВ шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг байгууллагын гадаадад цахим хуудсанд болон хамт олны цахим хуудсанд нээлттэй байршуулах | Жилдээ | Мэдээлэл технологийн алба<br><br>ЗАА-ны Олон нийттэй харилцах, хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн<br><br>Эдийн засаг, | - | Улсын нэгдүгээр төв эмнэлгийн гадаад цахим хуудсанд “Авлигын эсрэг үйл ажиллагаа” цонхыг нээсэн.<br>Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан болон АТГцаас гаргасан мэдээлэл, шторкыг тус тус байршуулан ажиллаж байна.<br>Цаашид мэдээллийг баяжуулан ажиллахаар зорьж байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | маркетингийн алба | |    |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>АТГ-аас хүлээлгэн өгсөн тараах материалыг ажилтан, үйлчлүүлэгч харах хсгүүдэд байршуулан ажилласан.<br><br>Цахим бүртгэлийн хүлээлгийн зааланд байршуулсан нь<br><br>Амбулаторын 1 давхрын заалны хэсэгт байрлуулсан нь |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | |   Захиргааны заалны хэсгийн мэдээллийн самбарт байрлуулсан |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br><br><br><br>Хаалгууд дээр тат, түлх наалтуудыг наасан<br><br>Албан тушаалтан, ажилтны ажлын өрөөний ширээн дээр<br>110 дугаар бүхий наалттай балыг байрлуулан |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Ажил, албан тушаалын сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулахдаа нээлттэй ил тод, зарчмыг баримтлан ажиллах | Тухай бүр | ЗХНА | - | Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь хүний нөөцийн нээлттэй, ил тод зарчмыг үйл ажиллагаандаа баримталж ажилладаг. УНТЭ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020.06.30-ны өдрийн 11 тоот тогтоолоор “УНТЭ-ийн удирдах ажилтан, ажилтан сонгон шалгаруулах” журмыг батлуулж мөрдөн ажиллаж байна.<br>● УНТЭ-ийн Захиргаа, хүний нөөцийн алба нь сул ажлын байрыг<br>- Эрүүл мэндийн хөгжлийн төв /hr.hdc.gov.mn/<br>- Монголын ажлын байрны төв сүлжээ /www.zangia.mn/<br>- Эмнэлгийн гадаад цахим хуудас /www.unte.moh.gov.mn/<br>- Эмнэлгийн гадаад нээлттэй фасебүүк сошиал маркетинг пэйж хуудас “Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг/ The First Central Hospital of Mongolia”<br>- Эмнэлгийн хамт олны хаалттай фасебүүк групп<br>- Хөдөлмөрийн үзэсгэлэн яармаг<br>- Их Дээд сургуулиуд дээр зохион байгуулагддаг өдөрлөг дээр нээлттэй, ил тод зарлаж ажилладаг.<br>● Мөн Захиргаа, хүний нөөцийн албанд бүртгэгдсэн хүний нөөцийн сангаас бүрдүүлэлт хийж сонгон шалгаруулалтад оролцогчдыг урьж оролцуулдаг.<br>Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь 2022.05.10-ны өдрийн байдлаар 13 ажлын байранд нийтдээ 17 сул ажлын байрыг ил тод, нээлттэй зарлаж ажилласан байна.<br>Сонгон шалгаруулалт зарласан ажлын байр, зарын тоо |

| № | Сонгон шалгаруулалт зарласан сул ажлын байр | Зарласан тоо |
|---|---|---|
| 1 | Дүрслэл оношлогооны техникч | 1 |
| 2 | Эмнэлзүйн эмгэг судлалын лабораторийн техникч | 2 |
| 3 | Лифт-талбайн үйлчилгээний ажилтан | 1 |
| 4 | Санхүү, бүртгэлийн албаны дарга | 1 |
| 5 | Слесарь | 3 |
| 6 | Сувилагч | 1 |
| 7 | Сургалт, эрдэм шинжилгээ, хамтын ажиллагааны албаны дарга | 2 |
| 8 | Туслах сувилагч | 1 |
| 9 | Үйлчлэгч | 3 |
| 10 | Цахилгаанчин | 1 |
| 11 | Эмзүйч | 2 |
| 12 | Амбулаторийн эрхлэгч /дотооддоо/ | 1 |
| 13 | Бөөрний төвийн зохицуулах сувилагч /дотооддоо/ | 1 |
| | Нийт | 20 |

Хүснэгт 2. УНТЭ-ээс зарласан сул ажлын байрны заруудын мэдээлэл

1) Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2022.03.01-ний өдрөөс эхлэн ашиглаж эхэлсэн хүний нөцийн HR.HDC.GOV.MN сайтанд 2022.05.09-ний өдрийн байдлаар 5 сул ажлын байрыг ил тод, нээлттэй байршуулж ажилласан байна.



Зураг 1. ЭМХТ-ийн hr.hdc.gov.mn сайт дээр байршуулсан сул ажлын байрны зар



Зураг 2. ЭМХТ-ийн hr.hdc.gov.mn сайт дээр байршуулсан сул ажлын байрны зар

2) Монголын ажлын байрны төв сүлжээ www.zangia.mn сайтанд 2022.01.02-2022.05.09-ний дуустал хугацаанд 11 сул ажлын байранд 15 удаа сонгон шалгаруулалтын зарыг ил тод, нээлттэй зарлаж байршуулж ажилласан байна. Үүнд:

| № | Сул ажлын байрны нэр | Хандалтын тоо | Зар тавьсан огноо | Зар зогсоосон огноо | Зарын хоног |
|---|---|---|---|---|---|
| 1 | Дүрслэл оношлогооны техникч | 35 | 3/17/2022 9:42 | 3/23/2022 8:45 | 6 хоног |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | Лабораторийн техникч | 52 | 3/17/2022 9:39 | 3/23/2022 8:47 | 6 хоног |
| 3 | Лабораторийн техникч | 90 | 2/8/2022 12:01 | 3/10/2022 23:59 | 30 хоног |
| 4 | Лифтчин-гадна талбайн ажилтан | 25 | 3/17/2022 9:37 | 3/24/2022 13:10 | 7 хоног |
| 5 | Санхүү, бүртгэлийн албаны дарга, ахлах ня-бодогч | 138 | 4/7/2022 16:23 | 4/14/2022 17:01 | 7 хоног |
| 6 | Слесарь | 30 | 3/17/2022 9:35 | 3/24/2022 13:15 | 7 хоног |
| 7 | Слесарь | 59 | 1/3/2022 9:18 | 2/2/2022 23:59 | 31 хоног |
| 8 | Слесарь | 37 | 11/12/2021 11:53 | 11/22/2021 11:17 | 10 хоног |
| 9 | Сувилагч | 46 | 3/17/2022 9:44 | 3/23/2022 8:44 | 6 хоног |
| 10 | Сургалт эрд/шинжилгээ хам/ажиллагааны албаны дарга | 107 | 4/11/2022 15:27 | 4/19/2022 17:01 | 8 хоног |
| 11 | Туслах сувилагч | 61 | 3/17/2022 9:41 | 3/23/2022 8:46 | 6 хоног |
| 12 | Үйлчлэгч | 71 | 1/3/2022 9:17 | 2/2/2022 23:59 | 31 хоног |
| 13 | Үйлчлэгч | 87 | 12/3/2021 10:45 | 1/2/2022 23:59 | 31 хоног |
| 14 | Цахилгаанчин | 92 | 1/3/2022 9:17 | 2/2/2022 23:59 | 31 хоног |
| 15 | Эмзүйч | 182 | 1/20/2022 13:12 | 2/19/2022 23:59 | 30 хоног |
| 16 | Эм зүйч | 60 | 5/20/2022 12:11 | 6/19/2022 23:59 | 30 хоног |
| 17 | Сургалт эрдэм шинжилгээ, хамтын ажиллагааны албаны дарга | 90 | 2022/05/16 11:37 | 2022/05/23 17:00 | 7 хоног |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 18 | Үйлчлэгч | 47 | 5/16/2022 15:18 | 6/15/2022 23:59 | 30 хоног |

Хүснэгт 2. Zangia.mn дээр байршуулсан сул ажлын байрны зарын мэдээлэл



Зураг 3. Zangia.mn дээр байршуулсан сул ажлын байрны зарууд

3) Эмнэлгийн гадаад цахим хуудас www.unte.moh.gov.mn-д 2022.05.09-ний өдрийг дуустал хугацаанд 8 сул ажлын байрны зарыг нээлттэй, ил тод байршуулсан байна.



Зураг 4. www.unte.gov.mn дээр

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байршуулсан сул ажлын байрны зарууд<br>4) Эмнэлгийн гадаад нээлттэй фасебүүк сошиал маркетинг пэйж хуудас 2022.05.09-ний өдрийг дуустал хугацаанд 12 сул ажлын байрны зарыг нээлттэй, ил тод байршуулсан байна.<br><br><br>Зураг 5. Эмнэлгийн гадаад нээлттэй фасебүүк сошиал маркетинг пэйж хуудас дээр байршуулсан сул ажлын байрны зарууд<br>5) Эмнэлгийн хамт олны хаалттай фасебүүк группт 2022.05.10-ны өдрийн байдлаар дотооддоо 2 сул ажлын байрыг нээлттэй, ил тод байршуулж ажилласан. Үүнд: 2022.04.01-ний өдөр Амбулаторийн эрхлэгчийн, 2022.05.06-ны өдөр Бөөрний төвийн зохицуулах сувилагчийн сул |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажлын байрууд байна.<br><br><br>Зураг 6. Эмнэлгийн дотоод хаалттай фасебүүк сошиал маркетинг пэйж хуудас дээр байршуулсан сул ажлын байрны зарууд |
| | | Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийн дагуу өргөдөл, гомдлыг судалж тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх | Тухай бүр | Эмнэлгийн дэргэдэх Ёс зүйн салбар хороо | - | УНТЭ-ийн дэргэдэх ЁЗСХ-нд 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар 3 өргөдөл ирсэнийг ЭМС-ын 2019 оны “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”, 2017 оны А/256 тоот тушаал, Монгол улс болон ОУ-д мөрдөгдөж буй хууль, тогтоомжуудыг судлан хуулийн хугацаанд холбогдох нотлох баримтуудыг бүрдүүлэн хуралдан шийдвэрлээд байна.<br>Эвлэрүүлэн зуучилсан өргөдөл шийдвэрлэлт – 1, Эмнэлгийн дэргэдэх Ёс зүйн салбар хороо болон ЭТҮЧАБА, Амбулаторийн эрхлэгч, Зүрхний төвийн даргыг байлцуулан өргөтгөсөн хурлаар |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>шийдвэрлэсэн өргөдөл -1, 2017 оны А/256 тоот тушаалыг үндэслэн Эмнэлгийн дэргэдэх Ёс зүйн салбар хорооноос шийдвэрлэсэн өргөдөл 1 байна.<br>Эмнэлгийн дэргэдэх Ёс зүйн салбар хорооны нарийн бичиг тухай бүр өргөдлийг хүлээн авч, бүртгэлийн хуудсыг хөтлөн ЁЗСХ-ны дарга болон гишүүдэд албан ёсоор танилцуулан өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлүүлэн ажиллаж байна.<br><br>УНТЭ-ийн дэргэдэх Ёс зүйн салбар хороонд ирүүлсэн өргөдлийг хүлээн авч, бүртгэх хуудас<br>
<table>
<tr><td colspan="2">Баримт бичгийн нэр төрөл</td><td colspan="2">Хаанаас, хэнээс буюу хаана, хэнд</td></tr>
<tr><td colspan="2">Баримт бичгийг хүлээн авсан</td><td colspan="2">Баримт бичгийн</td></tr>
<tr><td>Сар, өдөр</td><td>Бүртгэлийн дугаар</td><td>Огноо</td><td>Дугаар</td></tr>
<tr><td>2022.02.01</td><td>№ 2022/01</td><td>2022.02.01</td><td>-</td></tr>
<tr><td colspan="4">Баримт бичгийн гарчиг /товч утга/</td></tr>
<tr><td colspan="4">Удирдлагын заалт хэнд шилжүүлсэн</td></tr>
<tr><td colspan="4">Баримт бичгийн шийдвэрлэх хугацаа</td></tr>
</table></td></tr>
<tr><td></td><td></td><td>Байгууллагын тусламж, үйлчилгээ болон төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой гомдол мэдээллийг хүлээн авах, мэдээллийн бүртгэл, шийдвэрлэлтийн тогтолцоог бүрдүүлэх</td><td>Тухай бүр</td><td>УНТЭ-ийн Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын алба ЗХНА-ны бичиг хэрэг, нууцын эрхлэгч Ёс зүйн салбар хороо</td><td>-</td><td>УНТЭ-ийн чанар аюулгүй байдлын албанд тусламж, үйлчилгээтэй холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн байдал:<br>1. Өргөдөл гомдлын тоо, ирсэн хэлбэр<br><br>2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс – 2022 оны 05 дугаар сарын 10-ны байдлаар УНТЭ-ийн “Эмнэлгийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын алба”-нд иргэд, үйлчлүүлэгчдээс нийт 60 талархал, хүсэлт, өргөдөл гомдол ирсэн байна. Нийт ирсэн өргөдлүүдийг бичиг хэргийн ажилтан албан бичгийн программд бүртгэн авч, холбогдох албан тушаалтанд шилжүүлдэг.<br>Өргөдөл, гомдлын төрөл<br>
<table>
<tr><td>д/д</td><td>Төрөл</td><td>Бодит тоо</td><td>Нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь</td></tr>
<tr><td>1</td><td>Гомдол</td><td>48</td><td>80%</td></tr>
<tr><td>2</td><td>Санал</td><td>-</td><td>-</td></tr>
<tr><td>3</td><td>Хүсэлт</td><td>3</td><td>5%</td></tr>
<tr><td>4</td><td>Талархал</td><td>9</td><td>15%</td></tr>
<tr><td></td><td>Нийт</td><td>60</td><td>100%</td></tr>
</table></td></tr>
</table>

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, талархал /ирсэн хэлбэрээр/

| | Нийт ирсэн тоо | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Бичгээр | 11-11төв | Цахимаар | Утсаар | Амаар | Бусад |
| 1.Гомдол | 48 | 11 | 27 | 1 | 4 | 5 | - |
| 2.Санал | - | - | - | - | - | - | - |
| 3.Хүсэлт | 3 | 2 | | | | 1 | |
| 4.Талархал | 9 | 6 | 3 | - | - | - | - |
| **Нийт** | **60** | **19** | **30** | **1** | **4** | **6** | - |

**2. Өргөдөл гомдлын ангилал**

Иргэд, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг ЭМС-ын 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/50 тоот тушаалын дагуу өргөдөл, гомдлыг доорхи агуулгаар ангилдаг.

Өргөдөл, гомдлын агуулга

| д/д | Төрөл | Өргөдөл, гомдлын тоо | Нийт өргөдөлд эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Эмчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой | 23 | 47,9% |
| 2 | Эмч ажилчдын мэргэжлийн чадвар, харилцаа хандлага, ёс зүйтэй холбоотой | 18 | 37,5% |
| 3 | Эмчилгээний төлбөр, дэмжлэг хүсэхтэй холбоотой | 3 | 6,2% |
| 4 | Улирал, цаг үеийн шинжтэй зонхилж байгаа асуудал | 3 | 6,2% |
| 5 | Бусад | 1 | 2% |
| | **Нийт** | **48** | |

**3. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт**

| Д/д | | Нийт ирсэн тоо | Шийдвэрлэлт | | | Хугацаа болоогүй | Шийдвэрлэлт хувиар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Шийдвэрлэж хариу өгсөн | Бусад байгууллагад шилжүүлсэн | Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн | | |
| 1. | Өргөдөл, гомдол | 48 | 47 | 0 | 0 | 1 | 98 % |
| 2. | Санал | - | - | - | - | - | - |
| 3. | Хүсэлт | 3 | 3 | 0 | 0 | 0 | 100 % |

КОВИД-19 цар тахлын тохиолдол буурч улбар шар түвшинээс шар түвшин рүү зэрэглэл буурсантай холбоотой эмнэлгийн хэвийн үйл

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагаа сэргэн эмч нарын яриа 2022 оны 03 дугаар сарын 23-аас эхлэн долоо хоног бүр тогтмол зохион байгуулагдаж байгаатай холбогдуулан сар бүр өргөдөл гомдлын тайланг эмч нарт танилцуулан дотооддоо ярилцдаг<br>Үйлчлүүлэгч нарын гаргасан гомдлын дагуу холбогдох тасаг нэгжүүдтэй чанарын багийн өргөтгөсөн хурлуудыг зохион байгуулж хурлын тэмдэглэл, гарсан шийдвэрүүдийг тэмдэглэж бүртгэлжүүлэн ажилладаг.<br><br>Эмч, эмнэлгийн ажилтны харилцаа хандлага, ёс зүйтэй холбоотой гарсан гомдлуудад УНТЭ-ийн Захиргаа хүний нөөц хөгжлийн алба, Ёс зүйн хорооноос ажилчдад харилцаа хандлага ёс зүйн сургалт, семинарыг оруулан ажилладаг.<br>Нийт 48 өргөдөл гомдлын<br><br>❖ 11 (22,9%) нь үйлчлүүлэгчийн өөрсдийн буруу ойлголт, буруутай үйлдлээс шалтгаалсан учир эмнэлгийн тусламж үйлчилгээний үйл ажиллагааг зөв тайлбарлан өргөдөл гомдлыг хаасан.<br>❖ 15 (31,25%) нь эмнэлгийн тусламж үйлчилгээний оочер дараалал, хүлээгдэлтэй холбоотой гомдлууд ээлж байгаа бөгөөд хэвтэлт, шинжилгээ, хагалгааны хүлээгдлийн учир шалтгааныг тайлбарлаж, хүлээгдлийг зохицуулж болох иргэд үйлчлүүлэгч нарт хүндрэл чирэгдэл учруулахгүйгээр тусламж үйлчилгээг хүргэн гомдлыг хаасан.<br>❖ 1 (2%) нь эмнэлгийн тусламж үйлчилгээний төлбөрийг буцаан авах хүсэлтэй гомдлыг үйлчлүүлэгчид төлбөрийг нь буцаан олгож хаасан. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ❖ 11 (22,9%) үйлчлүүлэгчид мэдээллийг үнэн зөвөөр ойлгуулж чадаагүй, эмч ажилчдын харилцаа хандлага, ёс зүйтэй холбоотой гарсан гомдлууд тус тус эзэлж байна.<br><br>**4. Өргөдөл гомдлын тайлан мэдээдэл, ил тод байдал**<br><br>Өргөдөл гомдлын тайланг ЭМС-ын 2022 оны А/50 тоот тушаалын дагуу улирал бүр Эрүүл мэндийн яам руу хүргүүлэн ажилладаг. 2022 оны 01 дүгээр улирлын тайланг 2022 оны 03 дугаар сарын 28 ны өдөр хүргүүлэн ажилласан.<br>Өргөдөл гомдлын ил тод байдлыг хангаан 1-р улирлын өргөдөл гомдлын тайланг Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг/The First Central Hospital of Mongolia фейсбүүк пейж хуудсаар дамжуулан танилцуулан ажилласан. |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>



**5. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ**

Нийт эмнэлгийн эмч, ажилчдад Эмнэлгийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын алба, Захиргаа хүний нөөцийн албатай хамтран “Ажилчдын хандлагыг нэмэгдүүлэх” 3 сарын хугацаатай аяныг зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

**Хавсралт – 3** Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэгт иргэдээс ирүүлсэн 2022 оны нэгдүгээр хагас жилийн өргөдөл гомдлын тайлан, шийдвэрлэлтийн талаарх мэдээдэл, хэрэгжүүлж
</td></tr>
</table>

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажилласан арга хэмжээний тайланг дэлгэрэнгүйгээр хавсаргав. |
| | | Өргөдөл, гомдлыг программаар заавал бүртгэх, өргөдөл, гомдлын утга агуулгыг ангилж бүртгэх, мөн шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг оруулж хэвших | Жилийн турш | ЗХНА-ны бичиг хэрэг, нууцын эрхлэгч | - | Өргөдөл, гомдлын програмд бүртгэлийг утга, агуулга, шийдвэрлэлтээр ангилан бүртгэж хэвшсэн. 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар УНТЭ-т нийт 287 өргөдөл, гомдол, хүсэлт бүртгэгдсэн байна. Үүнээс шийдвэрлэсэн 237, шийдвэрлэх шатандаа болон хугацаа болоогүй 45 өргөдөл, гомдол, хүсэлт байна   |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Ирсэн болон явсан бичгийн бүртгэлийг сайжруулж, бичгийн утга, агуулгыг тодорхой бичиж, бүртгэж хэвших | Тухай бүр | ЗХНА-ны бичиг хэрэг бичиг хэрэг, нууцын эрхлэгч | - | 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар УНТЭ-н албан хэрэг хөтлөлтийн able программ болон хамтран ажилладаг харилцагч байгууллагуудаас 453 албан бичиг ирсэн.<br>Үүнээс хариутай албан бичиг- 82, хугацаандаа шийдвэрлэсэн – 77, шийдвэрлэх шатандаа болон хугацаа болоогүй албан бичиг-5, хариугүй албан бичиг- 376 байна.<br>Дээд газраас ирсэн чиглэл хүргүүлэх албан бичиг-18, Зөвлөмж хүргүүлэх-7, Тушаал-8, Тогтоол-2 эмнэлгийн албан хэрэг хөтлөлтийн Smart программд бүртгэгдсэн байна.<br> |
| | | Архивын нөхөн бүрдүүлэлтийг хугацаанд нь бүрдүүлэх, цахим хэлбэрт шилжүүлэх, хадгалалтын багтаамж, аюулгүй байдал, найдвартай ажиллагаа хэрэглээ, эрэлтэд оруулах нөхцлийг хангах ажлыг зохион байгуулах ажлыг эхлүүлэх | Жилийн турш | УНТЭ архив | 2,000,000₮ | УНТЭ-ийн архивт 8377 хадгаламжийн нэгж, барилгын зураг төслийн баримт болон хувийн гаралтай 1, зураг төслийн 69, гэрэл зураг 66, дуу дүрсний тусгай төрлийн 56 gb цахим хэлбэрээр хадгалагдаж байна.<br>2022 оны эхний улиралд 2021 оны хөтлөх хэргийн жагсаалтын дагуу баримтыг байгууллагын архивт хуваарийн дагуу зохион байгуулалтын нэгжүүдээс 450-иад захиргааны баримт, 18000-д өвчний түүхээр нөхөн бүрдүүлэлт хийсэн.<br>2016 - 2021 онд 720 хадгаламжийн нэгжээс лавлагаа хуулбарыг олгосон. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Архивын удирдлагын болон тоо бүртгэлийн баримтыг цахим хэлбэрт шилжүүлэн hard дискэнд хадгалж байна.<br>Тус эмнэлгийн өвчний түүх 2017 оноос эхлэн цахим хэлбэрт шилжсэн бөгөөд өвчний түүхийн хуулбарыг цахим сангаасаа хэвлэн олгож байна.<br>**Хавсралт – 4** Архивын тоо мэдээ хүргүүлэх албан бичгийг хавсаргав. |
| **Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, хариуцлагыг дээшлүүлэх** | | | | | | |
| 3 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах | Санхүү бүртгэлийн албанаас дараах үйл ажиллагааг тухайн хугацаанд хэрэгжүүлэн ажиллах Үүнд:<br>1. Тухайн жилийн төсөв /1 дүгээр сарын 10-ны дотор/<br>2. Өмнөх оны төсвийн гүйцэтгэл /4 дүгээр сарын 1-ний дотор/<br>3. Дараа жилийн төсвийн төсөл /8-р сарын 15-ны дотор/<br>4. Жилийн эцсийн санхүүгийн тайлан /5 дугаар сарын 1-ний дотор/<br>5. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /5 дугаар сарын 1-ний дотор/<br>6. Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаар мэдээлэх /өөрчлөлт орсноос хойш ажлын 14 хоногт/<br>7. Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох /татварын | Жилийн турш | Санхүү бүртгэлийн алба | - | 1. 2022 оны 1 дүгээр сарын 15-ны дотор 2022 оны төсөв 72.1 тэрбум төгрөг<br>2. 2022 оны 4-сарын 25-ны дотор 2021 оны төсвийн гүйцэтгэл 49.5 тэрбум төгрөг<br>3. 2022-2023 оны төсөвийн төсөөлөлийг 9-р сарын 15-ны дотор 72.1 тэрбум төгрөг<br>4. 2022 оны 4-сарын 25-ны дотор 2021 оны санхүүгийн тайлан 66.9 тэрбум төгрөг<br>5. 2022 оны 4-сарын 25-ны дотор 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт<br>6. ТУЗ-ын тогтоол 2022 оны 04- дүгээр сарын 26-ны өдөр. 06 тоот 66.9 тэрбум. Анхны батлагдсан төсвийн нийт дүнд өөрчлөлт ороогүй. Харин саруудын дүн хооронд өөрчлөлт хийв. Нийт төсөв 72 тэрбум.<br>7. 2022 оны 5 сарын 9-ны байдлаар ХХОАТатварт улсын төсөвт 583,4 сая төгрөг төвлөрүүлсэн<br>8. Ковид 19 цар тахалтай холбоотой материаллаг хандивыг сар бүр буюу 3 сард 213,1 сая төгрөг<br>9. 2022 оны 1-4 сарын байдлаар таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого 26,4 тэрбум, зарлага 19,4 тэрбумын гүйлгээг тухай бүр байршуулсан |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | орлогын талаарх мэдээлэл/<br>8. Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан /Бүтэн жилээр, хагас жилээр/<br>9. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөний гүйлгээ /Тухай бүр/<br>10. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр /Тухай бүр/<br>11. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилт, явц байдлын талаарх мэдээлэл<br>12. Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан /бүтэн жилээр/<br>13. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий | | | | 10. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг тухай бүр нь шилэн дансанд байршуулсан<br>11. Одоогын байдлаар гадаадын зээл тусламж хэрэгжээгүй байна. БНСУ-ын ССтөсөл /ШУТС/<br>12. 2020 оны аудитын тайлангийн дүгнэлтийн дагуу 2021 онд авч хэрэгжүүлэсэн арга хэмжээг хавсаргав. 2021 оны аудитын тайлангийн дүгнэлтийн дагуу ажлыг хийж эхэлж байна.<br>13. Тухай бүр шилэн дансанд байршуулсан<br><br>**Хавсралт – 5** Санхүүгийн холбогдох мэдээ тайлан, аудитын дүнэлтийг хавсаргав. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг /тухай бүр/ | | | | |
| | | Улсын төсвийн хөрөнгийн зарцуулалтын талаар иргэдэд нээлттэй ил тод мэдээлэх | Жилийн турш | Санхүү бүртгэлийн алба | - | УНТЭ-ийн шилэн дансанд төсөв, гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт, бусад мэдээллүүд шилэн дансанд тогтмол мэдээлэгдэж байна. https://shilendans.gov.mn/org/1284  |
| **Дөрөв. Худалдан авах ажиллагааны хяналт, хариуцлага, үр ашгийг нэмэгдүүлэх** | | | | | | |
| 4 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах<br>1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө<br>2. Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга<br>3. Тендер шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл /шалгарсан болон шалгарч | Жилдээ | Эдийн засаг, маркетингийн алба<br><br>Тендерийн үнэлгээний хорооны нарийн бичиг | - | Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны А/12 тоот тушаалаар байгуулагдсан өндөр өртөгт эмнэлгийн хэрэгслийн тендерийн үнэлгээний хороо нь нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй.<br>Эдийн засаг, маркетингийн албанд зарлагдаж буй өндөр өртөгт эмнэлгийн хэрэгслийн нээлттэй тендер нийт 105 багцтай бөгөөд үүнээс 57 багцад 19 компанитай 8,137,013,144 төгрөгийн гэрээ байгуулан ажилласан байна.<br>Мөн шалгараагүй 48 багцад нийт 4,4090,592,000 төгрөгийн хязгаарлагдмал тендер шалгаруулалт дахин зарлагдсан байна.<br>Онцлог тусламж үйлчилгээний эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж худалдан авах үнэлгээний хороо нь 2022 оны 01 дүгээр сарын 18-ны А/14 тоот тушаалаар Онцлог тусламж үйлчилгээний хэрэгслийн тендерийн үнэлгээний хороо нь нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | чадаагүй шалтгаан нөхцөл, хуулийн үндэслэл/<br>4. Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайлан | | | | байгуулагдсан. Үнэлгээний хорооны дарга Ч.Энхболд өөрийн хүсэлтээр ажлаас гарсан тул 2022 оны 03 дугаар сарын 14-ны А/75 тоот тушаалаар тус үнэлгээний хороог 7-н хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан болно. Нийт 45 багцтай үүнээс 26 багцад 8,802,431,916 төгрөгийн багцад гэрээ байгуулагдсан. Шалгараагүй 19 багц, нийт 1,090,745,410 төгрөгийн төсөвтэй дахин тендер зарлагдаж байна.<br>Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны А/13 тоот тушаалаар байгуулагдсан Үндсэн тусламж үйлчилгээний эм, эмнэлгийн хэрэгсэл урвалжийн тендерийн үнэлгээний хороо нь нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй.<br>Үндсэн тусламж үйлчилгээний эм, эмнэлгийн хэрэгсэл урвалж худалдан авах нээлттэй тендер нийт 131 багцтай бөгөөд үүнээс 81 багцад 26 компанитай 7,433,464,007 төгрөгийн гэрээ байгуулан ажилласан байна.<br>Мөн шалгараагүй 50 багц нийт 1,239,852,141 төгрөгийн хязгаарлагдмал тендер шалгаруулалт дахин зарлагдсан байна.<br>Дотоод шүүрлийн кабинетийн үнэлгээний хороо нь 2022 оны 01 дүгээр сарын 28-ны А/25 тоот тушаалаар нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. Нэг компани оролцож 49,887,806 төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж гэрээний хугацаанд тухайн ажлыг гүйцэтгэж хүлээлгэн өгсөн болно. |
| | | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9-р заалтын дагуу тендерийн үнэлгээний хороонд ажиллаж байгаа ажилтнууд мэдэгдэл тайлбарыг тухай бүр гаргах | Жилдээ | Тендерийн үнэлгээний хорооны нарийн бичиг ЭБАТ | - | 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар нийт 17 тендерийн үнэлгээний хороо шинээр болон шинэчлэн батлуулж байгуулсан. Тендерийн үнэлгээний хороонд томилогдон ажиллаж буй дарга, нарийн бичиг, гишүүдээс Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан АТГ-ын Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн системд бүртгэн дэвтэрт давхар хөтлөн ажиллаж байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | |  |
| | | А3 гэрчилгээтэй ажилтны судалгааг гаргах, сургалтад нэмж хамруулах ажлыг зохион байгуулах | Жилдээ | Эдийн засаг, маркетингийн алба | | Улсын нэгдүгээр төв эмнэлэгт худалдан авах ажиллагааны А3 сертификаттай 24 албан тушаалтан, ажилтан ажиллаж байна.<br>2022 онд байгууллагын бодлогоор худалдан авах ажиллагааны А3-тай албан тушаалтан, ажилтны тоог нэмэгдүүлэх зорилгоор 2.125.000 төгрөгийн төлбөрийг байгууллага хариуцан 25 албан тушаалтан, ажилтныг сургалтанд хамруулсан. **Хавсралт – 6** Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендер шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл |
| **Тав. Төрийн болон иргэний нийгмийн байгууллагын идэвхи санаачлага, оролцоог дэмжих** | | | | | | |
| 5 | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | Иргэний нийгмийн байгууллагын идэвхи санаачлага, оролцоог дэмжих | Жилдээ | Холбогдох албад | Тухайн үйл ажиллагаатай холбогдон гарах зардал, төсвөөр | Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь үйл ажиллагааны хүрээнд чиглэл бүрээр дараах, нийгэмлэг холбоод, ТББ-тай хамтран ажиллаж байна. Үүнд:<br>1. Монголын сайн сайхны төлөө нийгмийн ил тод байдлын нэгдсэн судалгаа ТББ – УНТЭ-тэй холбоотой өдөр тутмын сонин болон идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг мэдээллийн 150 гаруй сайтууд, хамгийн олон хандалттай сошиал хуудсуудад харилцагчийн болон холбоотой түлхүүр үгээр нийтлэгдсэн мэдээ, мэдээллийг цаг алдалгүй харилцагч талд үзүүлэх үйлчилгээг хүргэх. Мөн УНТЭ-ийг сурталчилсан фото, видео, мэдээ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээллийг бэлтгэж report.mn, niislelmedee.mn сайтуудад нийтлэх ажлыг хийж гүйцэтгүүлэх<br>2. Эрүүл мэнд хөгжлийн зуун ТББ – УНТЭ-ийн ажилтнуудын сургалт, хөгжил, нийгмийн баталгааг хангах, амины орон сууцжуулах чиглэлд<br>3. Чанарын менежерүүдийн холбоотой хамтран Чанарын 2 менежер, сувилахуйн албаны даргыг 35 багц цагийн чанарын сургалтанд хамруулав.<br>4. Мэргэжлийн нийгэмлэг, холбоодтой хамтран эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд мэргэшлийн зэрэг хамгаалах, сургалт, семинар зэрэг ажлуудаар хамтран ажиллаж байна.<br>5. Монголын сувилагчийн нийгэмлэг – Сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн мэргэшлийн зэрэг, сургалт, зохион байгуулах, нийгмийн хамгаалал, сургалт, хөгжлийн чиглэлээр хамтран ажиллаж байна.<br>6. Монголын хуульчдын холбоо ТББ, Энх гэрэлт хас НҮТББ, Худалдан авах ажиллагааны хөтөч ТББ, Нийгмийн хөгжлийн ертөнц ТББ, Монголын эмнэлгийн инженерчлэлийн нийгэмлэг ТББ – зэрэг байгууллагуудаас төлөөллийг УНТЭ-ийн худалдан авах үйл ажиллагаа, ажил сонгон шалгаруулахтай холбоотой тендерийн үнэлгээний хороонуудад оролцуулан ажиллуулж байна. |
| | | Авлигатай тэмцэх газар болон Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулсан аян, арга хэмжээ, бусад үйл ажиллагаанд идэвхтэй нэгдэн оролцох | Жилдээ | ЭМЯ-ны удирдамжийн хүрээнд ЭБАТ бусад алба | Тухайн аянтай холбогдон гарах зардал, төсвөөр | Мөн Авлигатай тэмцэх газраас "Зөв зөвд шударга зөв" аяныг улсын хэмжээнд зохион байгуулж байгаатай холбоотой нийтийн сүлжээг ашиглан авлигатай тэмцэх үйл ажиллагааг сурталчлан таниулах, үнэн зөв мэдээ мэдээллийг бодит эх сурвалжаас түгээх зорилготой |

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>нэгжтэй хамтран зохион байгуулах</td>
<td></td>
<td>"Авлигатай тэмцэх газар" пэйж хуудас, "АТГ-Олон нийтийн төв" фэйсбүүк пэйж хуудсыг тус тус хөтлөн ажиллуулж, мэдээ мэдээллийг олон нийтэд тасралтгүй хүргэн ажиллаж байгааг АТГ-ын 2022.03.18-ны 01/3817 тоот албан бичгээр ЭМЯ-нд ирүүлсэн. Уг үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд бүх шатны төрийн албан хаагчдыг үүрэг оролцоо их байгаа тул дээрх хоёр пэйжид нэгдэн дагахыг нийт ажилтнуудаа уриалж ажилласан.




Улсын нэгдүгээр төв эмнэлгийн гадаад цахим хуудсанд “Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа” буланг нээсэн.
Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан болон АТГцаас гаргасан мэдээлэл, шторкыг тус тус байршуулан ажиллаж байна.</td>
</tr>
</table>

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Цаашид мэдээллийг баяжуулан ажиллахаар зорьж байна.<br><br><br><br> |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Авлигын эсрэг үйл ажиллагаа мэдээлэн сурталчлах мэдээллийн самбар ажиллуулах | Жилдээ | ЗАА-ны Олон нийттэй харилцах, хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн<br><br>Эдийн засаг, маркетингийн алба<br><br>ЭБАТ | 960,000₮ | Улсын нэгдүгээр төв эмнэлгийн гадаад цахим хуудсанд “Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа” буланг нээсэн.<br>Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан болон АТГцаас гаргасан мэдээлэл, шторкыг тус тус байршуулан ажиллаж байна.<br>Цаашид мэдээллийг баяжуулан ажиллахаар зорьж байна.<br><br><br><br>Ажилтан болон үйлчлүүлэгчдэд авлигын эсрэг болон ёс зүйн чиглэлээр мэдээ, мэдээлэл хүргэх, |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сурталчлах самбарын загварыг гарган хэвлэлийн компанид хүргүүлэхээр ЗАА ажиллаж байна.   |
| **Зургаа. Авлигын эсрэг боловсролыг дэмжих** | | | | | | |
| 6 | Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, бусад | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах | Жилдээ | ЭБАТ | - | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүрийн эхэнд батлуулан ажиллаж байна.<br>Мөн батлагдсан төлөвлөгөөг байгууллагын гадаад сайтад ил тод мэдээлэв.<br>Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас болон бүтэн жилээр тайлагнан ажиллаж байна.<br> |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | АТГ-т тухайн жил авлигын эсрэг сургалт авах захиалга өгөх | - | ЭБАТ | - | УНТЭ-д дараах сургалтын хэрэгцээ шаардлага байгааг АТГ-ын Эрүүл мэндийн салбар хариуцсан ажилтан У.Номин – Эрдэнэд уламжлаад байна.<br>1. Нийт ажилтнуудад авлигын эсрэг хууль эрх зүйг сурталчлах мэдлэг олгох<br>2. Худалдан авалт, тендерийн үнэлгээний хороонд ажилладаг гишүүдэд холбогдох хууль, тогтоомжоор<br>3. Шинээр томилогдсон удирдах ажилтнуудад хууль, эрх зүй, анхаарах асуудлуудаар<br>4. Эмнэлгийн мэргэжилтнүүдэд давхар ажил эрхлэлт<br>5. Бэлэг<br>6. Албан бус төлбөр<br>7. ЭМ-ийн салбарт гарсан авлига, ашиг сонирхлыг кейсүүдээр тайлбарласан сургалт маш хэрэгтэй байна.<br>8. Хандив<br><br>УНТЭ-ийн Ерөнхий захирлын 2022.05.18-ны өдрийн 1/655 тоот “Сургалт авах хүсэлт хүргүүлэх тухай” албан бичгээр АТГ-аас дээрх сэдвийн хүрээнд сургалт авах хүсэлтийг илгээн хамтарч ажиллахаар төлөвлөж байна. |
| | | Албан хаагчдад ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар сургалт зохион байгуулах | Жилдээ | АТГ болон ЭМЯ-тай хамтран УНТЭ | 1,000,000₮ | <u>Авлигын эсрэг сургалт</u><br>АТГ болон ЭМЯ-наас зохион байгуулсан сургалтын зарыг тухай бүр эмнэлгийн удирдах албан тушаалтнуудад албан ёсоор мэдээлэн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургалтын линкийг цаг тухай бүрт илгээн ажиллав. Үүнд:<br>1. АТГ-аас ХАСХОМ мэдүүлэг гаргагч нарт зориулсан сургалтыг 2022 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр 10.00 цагаас онлайн хэлбэрээр зохион байгуулсан.<br><br>Join Zoom Meeting<br>https://us06web.zoom.us/j/87682759318?pwd=eUlwa0hUc1dTV2c2aWFpY2hGL05sZz09<br>Meeting ID: 876 8275 9318<br>Passcode: 110<br>Сургалтыг<br><br>2. АТГ-аас яамдын нийтийн албан тушаалтнуудад зориулсан сургалтын зарыг УНТЭ-ийн албан тушаалтнуудад албан ёсоор мэдээлэн цахим сургалтанд хамруулсан. Дараах хөтөлбөрийг илгээсэн. Үүнд:<br><br>Сургалтын зорилго: Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.1.10.3-т заасан “Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах” зорилтын хүрээнд төрийн байгууллагуудын албан хаагчдыг авлигын эсрэг хууль тогтоомж, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх.<br>Сургалт зохион байгуулах огноо: 2022 оны 2 дугаар сарын 25-ны өдөр , 09:00 цагт |

Сургалтын үргэлжлэх хугацаа: 120 минут
Сургалтад хамрагдах албан тушаалтан: Яамдын нийтийн албан тушаалтан
Сургалтын хэлбэр: АТГ-ын Олон нийтийн төв, цахим хэлбэрээр
Join Zoom Meeting
https://us06web.zoom.us/j/83075968178?pwd=MXpsUVNvaFRjT3F6dU5kcjZObFJ6QT09
Meeting ID: 830 7596 8178
Passcode: 110




3. УНТЭ-ийн ЭБАТ Удирдах албан тушаалтнууд буюу ХАСХОМ мэдүүлдэг албан тушаалтнуудад 2022.01.11-ний өдөр ХАСХОМ мэдүүлэхтэй холбоотой болон Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох заалтуудыг танилцуулан сургалтыг зохион байгуулсан.

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br><br><br><br>4. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, сонгон шалгаруулах ажлын хэсэгт ажиллаж буй албан тушаалтан, ажилтнуудад Эмнэлгийн ХАСХОМ хариуцсан ЭБАТ “Мэдэгдэл тайлбар гаргахтай холбоотой анхаарах асуудлууд” сэдвээр 2022.05.26-ны өдөр сургалтыг зохион байгуулав.<br> |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | |   |



ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА, НАРИЙН БИЧИГ, ГИШҮҮДЭД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ, МЭДЭГДЭЛ ТАЙЛБАР ГАРГАХТАЙ ХОЛБООТОЙ АНХААРАХ АСУУДЛУУД СУРГАЛТАНД ХАМРАГДСАН АЛБАН ТУШААЛТАН, АЖИЛТНУУДЫН ГАРЫН ҮСГИЙН БАТАЛГААЖИЛТ

2022.05.26

| № | Овог, нэр | Нэгж | Албан тушаал | Гарын үсэг |
|---|---|---|---|---|
| 1 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 2 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 3 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 4 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 5 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 6 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 7 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 8 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 9 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 10 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 11 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 12 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 13 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br><br><br><br>Сургалтын материалыг холбогдох албан тушаалтан, ажилтанд албан ёсны цахим хаяг руу илгээв.<br>**Хавсралт -7** УНТЭ-ийн ЭБАТ-аас зохион байгуулсан сургалтын материалууд<br>Ёс зүй сургалт болон хэрэгжүүлсэн аян<br>1. УНТЭ-ийн дэргэдэх Ёс зүйн салбар хорооноос Амбулаторийн тасгийн нийт ажилтнуудад 2022.03.24-ний өдөр “Хандлага”, “Бахархал” сэдвүүдээр сургалтыг зохион байгуулав. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>МОНГОЛ УЛСЫН АРДЫН ЭМЧ Н.ОЮУНДЭЛГЭР<br>ОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ГАВЬЯАТ ЭМЧ Ц.ИШДОРЖ НАРТАЙ<br>ХИЙХ ХҮНДЭТГЭЛИЙН УУЛЗАЛТ<br>АГУУ БАЙДАЛ ТАНЫ ДОТОР ОРШДОГ<br>ХАРИН НЭЭХ ЦАГ НЬ ЯГ ОДОО...<br>АМБУЛАТОРИЙН ТАСАГ<br>ЁС ЗҮЙН САЛБАР ХОРОО<br><br> |



2. УНТЭ-ийн дэргэдэх Ёс зүйн салбар хорооны нарийн бичиг Ч.Бямбасүрэн 2022.04.12-ны өдөр тус эмнэлэгт олгох болон дээшлүүлэхээр суралцахаар ирсэн 200 орчим эмнэлгийн мэргэжилтэнд Байгууллагын танилцуулга, Хандлага сэдвүүдээр сургалтыг зохион байгуулав.

Төгсөлтийн дараах Эмч мэргэжилтний Чиглүүлэх сургалтын хөтөлбөр

Хэзээ: 2022.04.12

Хаана: Улсын нэгдүгээр төв эмнэлэг, 4 давхрын хурлын их танхим

| № | Хугацаа | Сэдэв | Нэр, албан тушаал |
|---|---|---|---|
| 1 | 09:00-09:30 30 минут | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй товч ойлголт | Б.Энхтуул Захиргаа, Захирлын ажлын алба, Дотоод хяналтын мэргэжилтэн |
| 2 | 09:30-09:50 20 минут | Эмнэлгийн чанар, аюулгүйн байдал, суралцагч эмч нарын өвчний түүхийн түгээмэл алдаа | Э.Учрал Захиргаа, Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын алба, мэргэжилтэн |
| 3 | 09:50-10:20 30 минут | Эмч, эмнэлгийн ажилтны ёс зүй, хэм хэмжээ | Ч.Бямбасүрэн Захиргаа, Хүний нөөцийн алба, мэргэжилтэн, Ёс зүйн салбар хорооны нарийн бичгийн дарга |
| 4 | 10:20-10:50 30 минут | Халдвар хамгаалал | Ц.Очцацарал Захиргаа, Халдварын сэргийлэлт хяналтын алба, мэргэжилтэн |
| 5 | 10:50-11:20 30 минут | Цахим өвчний түүх хөтлөлт болон мэдээллийн аюулгүй байдал | П.Ганчимэг Мэдээлэл технологийн албаны дарга |
| 6 | 11:20-11:30 10 минут | Улсын нэгдүгээр төв эмнэлгийн танилцуулга, СЭШХААцны танилцуулга, Номын сангийн үйл ажиллагаа | Т.Одгэрэл Захиргаа, Сургалт, эрдэм шинжилгээ, хамтын ажиллагааны алба, Номын сангийн эрхлэгч |
| 7 | 11:30-11:45 15 минут | Сургалтын үйл ажиллагааны журам, мөрдөгдөх тушаал, журам | М.Лутзул, Захиргаа, Сургалт, эрдэм шинжилгээ, хамтын ажиллагааны алба, мэргэжилтэн |

Санамж: Халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зай баримталж сургалтанд оролцоно уу!

Чиглүүлэх сургалтанд хамрагдаагүй бол тасаг, төвд хуваарилахгүй

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3. УНТЭ-ийн дэргэдэх Ёс зүйн салбар хороо болон Захиргаа, хүний нөөцийн албанаас хамтран удирдамжийг боловсруулан эмнэлгийн Ерөнхий захирлаар батлуулан 2022 оны 3 дугаар сард ОУ-ын эмч нарын өдрийг тохиолдуулан “Шилдэг ёс зүй, харилцаа хандлагатай эмч”-ийг, 2022 оны 05 дугаар сард “Шилдэг ёс зүй, харилцаа хандлагатай сувилагч”, “Шилдэг ёс зүй, харилцаа хандлагатай тусгай мэрэгжилтэн”-г тус тус 1-ийг шалгаруулав. Шалгаруулалтыг 3-н үе шаттайгаар зохион байгуулав. 1-р шатанд нэгжүүд хуралдан 1 ажилтныг ЁЗСХ-нд материалыг ирүүлсэн бөгөөд 2-р шатанд ЁЗСХ-ноос тусгай шалгуурын дагуу 5, 5-н мэргэжилтэнг шалгаруулав. 3-р шатанд хамт олны цахим хуудсанд тус бүр шилдэг 5-н оролцогчийн зургийг байршуулан хамт олны санал, хандалт лайкаар тус бүр 1 шилдэг ёс зүй, харилцаа хандлагатай эмнэлгийн мэргэжилтэнг шалгаруулж урамшуулав.  |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | |   |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | |  [redacted]  <br>4. УНТЭ-ийн дэргэдэх ЁЗСХ-нд 2019-2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар ирүүлсэн өргөдөл, гомдолд үндэслэн нийт эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нарт дараах зөвлөмжийг ЁЗСХ-ны даргын 2022.03.07-ны өдрийн 16 тоот “Зөвлөмж хүргүүлэх тухай албан бичгээр хүргүүлсэн. Үүнд:<br>1. Нийт ажилтнууд Эрүүл мэндийн сайдын 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/406 тоот “Эмнэлгийн мэргэжилтний ёс |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зүйн дүрэм батлах тухай” тушаалыг бүрэн уншиж, бататган ойлгох<br><br>2. Удирдах ажилтнууд нэгж хамт олноо харилцаа, хандлагаараа үлгэрлэн манлайлах, дарамт шахалт үзүүлэхгүй байх. МУ-ын Засгийн газрын 2019 оны 33 тоот “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм” тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах. Уг тогтоолыг нэгжийн эрх зүйн хавтсанд байршуулан ажилтнууддаа танилцуулах<br><br>3. Эмнэлгийн мэргэжилтэн хоорондын харилцаа нь нэг нэгнийгээ харилцан хүндэтгэсэн, дэмжсэн, үйлчлүүлэгчийн эрх ашигт нийцсэн шударга, хамтын ажиллагааны зарчимд үндэслэх<br><br>4. Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчдэд өвчний онош, үзүүлсэн тусламж, үйлчилгээний талаар үнэн зөв, ойлгомжтой байдлаар мэдээлэх<br><br>5. Эмнэлгийн мэргэжилтэн бүр хоорондоо уялдаа холбоотой, багийн ажиллагааны зарчимд тулгуурлан ажиллах<br><br>6. Эмнэлгийн мэргэжилтний хариуцлагагүй байдал нь бусад ажилтны ажлын хариуцлага болон үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд ч нөлөөлөх боломжтойг анхаарах<br>7. Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нар нь шинэ ажилтнууддаа зөв, зөв үлгэр дуурайлал, манлайлалтай ажиллах<br>8. Эмнэлгийн мэргэжилтэн нь ажилтан, үйлчлүүлэгчдэд бэлгийн дарамт |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үзүүлэхгүй байх. Тухайн асуудалтай холбогдолтой эрсдэл, асуудал тулгарсан тохиолдолд нуун дарагдуулахгүй эрх бүхий байгууллагад шууд мэдээлэх<br>9. Албан тушаал, ажилласан жил, туршлага, ажил мэргэжлийн давуу байдлаар бусдад хүндлэлгүй хандаж болохгүй.<br>10. Эмнэлгийн мэргжилтэн нь үйлчлүүлэгчээс албан бус төлбөр авах, шаардах<br>11. Эмнэлгийн мэргэжилтэн нь үндэслэлгүйгээр бусдыгаа гүтгэх, хууран мэхлэх, гадуурхахгүй байх<br>12. Эмнэлгийн мэргэжилтэн өөр хоорондоо харилцан ярилцаж, ойлголцож, уучлалт гуйж чаддаг байх<br>13. Эмнэлгийн мэргэжилтэн бүр хариуцсан ажилдаа эзэн байх<br>14. Эмнэлгийн мэргэжилтэн нь өөрийн мэргэжил, үнэ цэнээр бахархах<br><br>УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ<br>УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН САЛБАР ХОРОО<br>Анхдагч, Манлайлагч<br>210648 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг С.Зоригийн гудамж-2, Утас/Факс: (976) 7011 1105 И-мэйл: firsthospital@fchm.edu.mn<br>2022.03.07 № 16<br>танай ___ -ны № ___ -т<br>УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН НИЙТ АЖИЛТНУУДАД<br>Зөвлөмж хүргүүлэх тухай<br>Улсын нэгдүгээр төв эмнэлгийн дэргэдэх Ёс зүйн салбар хороонд 2019-2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар ирүүлсэн өргөдөл, гомдолд үндэслэн нийт эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нарт дараах зөвлөмжийг хүргүүлж байна.<br>1. Нийт ажилтнууд Эрүүл мэндийн сайдын 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/406 тоот "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм батлах тухай" тушаалыг бүрэн уншиж, бататган ойлгох<br>2. Удирдах ажилтнууд нэгж хамт олноо харилцаа, хандлагаараа үлгэрлэн манлайлах, дарамт шахалт үзүүлэхгүй байх. МУ-ын Засгийн газрын 2019 оны 33 тоот "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм" тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах. Уг тогтоолыг нэгжийн эрх зүйн хавтсанд байршуулан ажилтнуудаа танилцуулах<br>3. Эмнэлгийн мэргэжилтэн хоорондын харилцаа нь нэг нэгнийгээ харилцан хүндэтгэсэн, дэмжсэн, үйлчлүүлэгчийн эрх ашигт нийцсэн шударга, хамтын ажиллагааны зарчимд үндэслэх<br>4. Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчдэд өвчний онош, үзүүлсэн тусламж, үйлчилгээний талаар үнэн зөв, ойлгомжтой байдлаар мэдээлэх<br>5. Эмнэлгийн мэргэжилтэн бүр хоорондоо уялдаа холбоотой, багийн ажиллагааны зарчимд тулгуурлан ажиллах<br>6. Эмнэлгийн мэргэжилтний хариуцлагагүй байдал нь бусад ажилтны ажлын хариуцлага болон үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд ч нөлөөлөх боломжтойг анхаарах<br>7. Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нар нь шинэ ажилтнууддаа зөрэг, зөв үлгэр дуурайлал, манлайлалтай ажиллах<br><br>8. Эмнэлгийн мэргэжилтэн нь ажилтан, үйлчлүүлэгчдэд бэлгийн дарамт үзүүлэхгүй байх. Тухайн асуудалтай холбогдолтой эрсдэл, асуудал тулгарсан тохиолдолд нуун дарагдуулахгүй эрх бүхий байгууллагад шууд мэдээлэх<br>9. Албан тушаал, ажилласан жил, туршлага, ажил мэргэжлийн давуу байдлаар бусдад хүндлэлгүй хандаж болохгүй.<br>10. Эмнэлгийн мэргжилтэн нь үйлчлүүлэгчээс албан бус төлбөр авах, шаардах<br>11. Эмнэлгийн мэргэжилтэн нь үндэслэлгүйгээр бусдыгаа гүтгэх, хууран мэхлэх, гадуурхахгүй байх<br>12. Эмнэлгийн мэргэжилтэн өөр хоорондоо харилцан ярилцаж, ойлголцож, уучлалт гуйж чаддаг байх<br>13. Эмнэлгийн мэргэжилтэн бүр хариуцсан ажилдаа эзэн байх<br>14. Эмнэлгийн мэргэжилтэн нь өөрийн мэргэжил, үнэ цэнээр бахархах<br>ЁС ЗҮЙН САЛБАР ХОРООНЫ ДАРГА Ц.ИШДОРЖ<br>**Хавсралт – 8** УНТЭ-ийн дэргэдэх Ёс зүйн салбар хорооны даргын 2022.03.07-ны өдрийн 16 тоот “Зөвлөмж хүргүүлэх тухай” албан бичиг |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |
| | | УНТЭ-ийн албан тушаалтнуудад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах | 1-4 дүгээр улирал | ЭБАТ | - | 1. УНТЭ-ийн ЭБАТ Удирдах албан тушаалтнууд буюу ХАСХОМ мэдүүлдэг албан тушаалтнуудад 2022.01.11-ний өдөр ХАСХОМ мэдүүлэхтэй холбоотой болон Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох заалтуудыг танилцуулан сургалтыг зохион байгуулсан. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>Сургалтын слайдыг албан ёсны цахим хаяг руу илгээв.<br><br>2 УНТЭ-ийн нийт удирдах албан тушаалтнуудад Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудыг мөрдүүлэх, хэрэгжилтийг хангах зорилгоор дээрх хуулиудыг хууль, эрх зүйн хавтсанд байршуулж, ажилтнууд танилцах бүрэн боломж, нөхцлөөр хангах, нэгжийн хамт олны цахим сүлжээнд байршуулах, сургалт болон хэлэлцүүлэг зохион байгуулах байдлаар хууль эрх зүйн мэдлэг олгох, бататгах үйл ажиллагаар дотооддоо зохион байгуулах болон хуулийн холбогдох заалтуудыг онцгойлон анхаарч ажиллах талаар “Хуулийг мөрдөн ажиллах тухай” албан бичгийг 2021.03.12 1/242, 2021.12.16 1/1263 тоот албан бичгүүдээр хүргүүлэн ажиллаж байна.<br>3 УНТЭ-ийн худалдан авах үйл ажиллагаанд оролцож буй албан тушаалтан, ажилтнуудад |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эмнэлгийн ЭБАТ сургалтыг зохион байгуулж, хамтран ажиллаж байна.<br><br><br><br><br><br> |



4 УНТЭ-ийн албан тушаалтнуудад ХАСХОМ мэдүүлэхтэй холбоотой гарын авлага, зөвлөгөө, зааварчилгаа албан ёсны цахим хаяг руу илгээн ажилласан. Мөн утсаар болон биечлэн зөвлөж ажиллаж байна.

2022 оны 01 дүгээр сард ХАСХОМ мэдүүлэхтэй холбоотой өгсөн зөвлөгөө, зааварчилгааны жагсаалт









| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br><br>АТГ-аас ирүүлсэн ХАСХОМ мэдүүлж дуусах хуулийн хугацааг сануулах мэйлийг 2022.02.11-ний өдөр илгээсэн.<br><br><br>Албан тушаалтнууд ХАСХОМ-ээ мэдүүлэхийг онцгойлон анхааруулсан цахим шуудан<br><br> |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>


<br>
АТГ-аас албан тушаалтнуудын 2021 оны ХАСХОМ-д шалгалт хийх тухай ЭМЯ-ны мэдээллийг цахим шуудангаар 2022.01.11-ний өдөр мэдээлэв.
<br>


<br>
УНТЭ-ийн хэмжээнд 2022.02.15-ны өдөр албан тушаалтнуудын ХАСХОМ бүрэн баталгаажсаныг мэдээлэв.
<br>


</td></tr>
</table>

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Монгол улсын Эрүүл мэндийн яамнаас ирүүлсэн 2022.05.24-ний өдрийн 2/2498 тоот “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлж, ажиллах тухай” албан бичгийн дагуу авлига, ашиг сонирхлын зөрчил гаргах эрсдлээс урьдчилан сэргийлэхийн тулд хандив, тусламж авах болон байгууллагын түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхдээ холбогдох хууль, журмыг мөрдөн ажиллах зөвлөмжийг 2022.06.06-ны өдөр нийт удирдах албан тушаалтнууд болон төв, тасгийн эрхлэгч, дарга нарт хүргэв.<br><br><br>ЭМЯ-наас ирүүлсэн 2022.05.24-ний өдрийн ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлж ажиллах т хүргэв.<br><br> |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Байгууллагын ЭБАТ-ыг чадавхижуулах сургалтад хамруулах | Жилдээ | АТГ<br>ЭМЯ<br>УНТЭ | - | ЭМЯ-ны ЭБАТ-аас шаардлагатай тохиолдол бүрт арга зүйн зөвлөгөө авч хамтран ажиллаж байна.<br>2022.01.14-ний өдөр ХАСХОМ-ийг шинэчлэн гаргуулж, бүртгэхтэй холбоотой үйл ажиллагааны талаар зөвлөгөөг ЭБАТ-ын нэгдсэн группээр дамжуулан өгсөн.<br><br>ЭМЯ-ны ЭБАТ-аас 2022.02.18-ны өдөр ХАСХОМ-ийн тайлан мэдээг гаргахтай холбоотой зөвлөмжийг өгсөн. |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>


ЭМС-ын ЭБАТ-ын нэгдсэн группээр дамжуулан төрөлжсөн эмнэлгийн ЭБАТ-ууд хоорондоо туршлага солилцон хамтран ажиллаж байна.


</td></tr>
</table>